

Монгол улсын хүн амын тооллого нь хүн амын мэдээллийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг мөн

Ц. Цэдэв
Улсын Иргэний Бүртгэл
Мэдээллийн төв

Монголчууд дээр үеэс эхлэн хүн ам, мал, агтны тоо бүртгэлийг хөтөлж байсан талаар түүх, судалгааны материалын бичигдэн үлдсэн байдаг. Тухайлбал, бүр XIII зууны үед Монголд мал, хүн амын тоо авч үр тариа, гар үйлдвэрийн үйлдэхүүний бүртгэл хөтөлж байжээ.

1. Нүүдлийн байдалтай байсан тэр үед бүртгэлийн материалыг хадгалах нөхцөл байхгүй, тэгээд ч статистик, нийгмийн танин мэдэх чухал хэрэгсэл болж чадахгүй байсан байна.

Чингэс хааны эзэнт улсын үед Монголын хүн амын тооны талаар дэхийн олон эрдэмтэд сонирхолтой тоо материалыг гаргасан байдаг. Тухайлбал, И. Захаров: Чингис хааны үед болон түүний хүү, ач хүүгийн үед 2.5 сая, Ч. Далай: 2 сая, Н. Ц. Мункуев: Чингис хааны хаанчлалын үед 700 мянган хүн амтай байсан бөгөөд төрөлт өндөр байсан тухайн үеийн мэдээ дээр тулгуурлан Юаны эзэнт улсын үед хүн амын тоо 2 дахин өсч, 1.5 сая болсон, Е. И. Кычанов: Чингис хааны эзэнт улсын үед 1 сая хүнтэй байсан, А. П. Алексеев: Чингис хааны үед Монголын хүн ам 500 мянга гэж тооцсон, Н. Хавх: жинхэнэ монголчууд 700 мянга, монголчууд хэмээгдэх нэгтгэсэн өвог аймгуудтайгаа нийлээд 1 сая 500 мянга орчим хүн байсан 4 гэх мэтчилэн тодорхойлсон байдаг,

Монголчууд хүн ам, цэрэг агтны бүртгэл дансыг хөтөлж байсан нь XI-XIII зууны монголчуудад тухайн үеийн төрийн бодлоготой холбоотой байсан нь гэж үзэх үндэслэлтэй байдаг.

Зөвлөлтийн эрдэмтэн С. В. Киселев "Эртний монголын хот" гэдэг бүтээлдээ "Монголчууд бүр 1236 онд хятадад хүн амын анхны тооллого явуулж алба гувчуур оногдуулав" гэж бичсэн байна. Үүнээс үзэхэд энэ нь Монголд явагдсан анхны тооллого биш, харин манж хятадыг эзлэн аваад хятадад явуулсан тооллого болох нь тодорхой байна. Жорж Вернадский "Чингис хааны их яса (засаг)-ийн судалгаа, түүний агуулга гэдэг" бүтээлдээ Монголын эзэмшилд улс орнууд, хүн амыг нэгтгэсэний дараа тооллого явуулж байхыг төрийн хуулиндаа заасныг тэмдэглэсэн байдаг.

Хүн ам, малын тооллого явуулж байсан нь тэр үеийн төр, нийгмийн тогтолцоотой холбогдолтой бөгөөд, тооллогын материал нь янз бүрийн алба татвар оногдуулах, цэрэг дайчлах гол тулгуур болж байлаа. 1921 оны Ардын хувьсналаас өмнө явагдаж байсан тооллого нь улсын хэмжээнд төвлөрсөн удирдлагагүй, зөвхөн орон нутгийн чанартай, аймаг хошуудынхаа хүрээнд явуулж, албан хэрэгцээндээ ашиглаж байсан байна. Эдгээр тооллогын материалыг эмхлэн цэгцэлж, нарийн нямбай хадгалж байгаагүй, улсын зүгээс тооллогын дүнг нэгтгэх гэсэн оролдлого төдий л байгаагүй, тэгээд ч нүүдлийн байдалтай байсан тэр үед тооллогын мате

риалыг хадгалах нөхцөл боломжоор бага байсан бололтой. Тэр үеийн Монголын нийгэмд хүн амын амьжиргаа, амьдралын түвшингийн гол үзүүлэлт болох малыг тоолж тодорхойлох, албан татвар ногдуулахдаа хүн ам, өрхийн тоог зайлшгүй гаргадаг байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм. Гагцхүү энэ тооллогын материал хувьсгалын өмнөх Монголын хүн амын тоог ойролцоогоор тодорхойлох цорын ганц эх сурвалж болсон гэж үзэх үндэстэй. Гэхдээ 1918 оны тооллогод Дархадын хязгаар, Хөвсгөл нуурын орчим, Ховдын хязгаарыг хамраагүй учир бүрэн хэмжээний мэдээлэл гэх үндэсгүй юм.

1918 оны тооллогын материалд тулгуурлан академич И. М. Майскийн тооцоолсноор гадаад Монголын хүн амын тоо 647.5 мянга байснаас 100 мянга нь Хятад, 5 мянга нь Орос байлаа. Иймд тус улсын үндсэн хүн ам 542.5 мянга байсан гэж тогтоосныг үндэслэлтэй зөв тоо ..." | гэж одоо хүртэл үзэж байна.

1921 оны Ардын хувьсгал хүн амын тоог бүрэн тодорхойлох бодит нөхцлийг бүрдүүлж Монголын статистикийн түүхэнд шинэ үеийг нээсэн гэж үздэг. Тухайлбал 1921–1923 онуудад хүн амын тоо бүртгэл орон нутгийн засаг захиргаадын санаачилгаар явагдаж байв. Монгол улсын засгийн газар 1924 онд Дотоод Яамны дэргэд эдийн засгийн хэлтсийг байгуулжээ. Энэ хэлтсийн гол ажил нь дөрвөн аймаг, шавийн мал хөрөнгө, хүн амын бүртгэлийг жилд нэг удаа явуулж тус орны аж ахуй соёлын бүтээн байгуулалт, эх орноо батлан хамгаалах, санхүүгийн болон албан татварын бодлогыг хэрэгжүүлэх, морин өртөөний ажлыг зохицуулах зэрэг тухайн үедээ тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны үндэстэй мэдээг гаргах шаардлагатай нийцсэн үйл ажиллагаа байв. Ингэснээр 1924 оноос хүн амын тоо бүртгэл нь улсын чанартай ажил болж, төвлөрсөн удирдлага, нэгдсэн програмтай явагдаж эхэлжээ. 1925 оноос эхлэн манай улсын хүн амын тоог жил бүр байнга гаргадаг болсон юм. 1930 оны дунд үе хүртэл хүн амын тоо бүртгэл нь "өрхийн данс" нэртэйгээр малын тооллоготой хамт явагдаж байв. 1935 онд бүх нийтийг хамарсан хүн амын тооллогыг малын тооллогоос тусгайд нь улсын хэмжээгээр зохион явуулж дүнг гараар нэгтгэн гаргажээ.

Хүн амын бүртгэлийг хөтлөх, мэдээг гаргах ажлыг 1941 онд Сайд нарын Зөвлөлийн дэргэд төлөвлөгөө, тоо бүртгэлийн хянан шалгах хороо, 1944 оноос Улсын төлөвлөгөөний комиссын тоо бүртгэлийн хэлтэс тус тус хариуцан эрхэлж байсан байна. 1948 оноос эхлэн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт тавигдсан тэр үесээ эдийн засгийг тодорхой хугацаанд хөгжүүлэх төлөвлөгөөтэй болж, түүний биелэлтийг сар, улирал, хагас жил, жилээр тогтмол авч дүгнэх болсон нь эдийн засгийн зорилт, хүн амын бодлоготой уялдуулах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. 1951 оноос эхлэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтөлж, төрөлт, нас барагтыг бүртгэж эхэлсэн нь хүн амын тоог хагас жил, жилээр тооцох үндэс суурь тавигдсан гэж үзэх үндэстэй. 1960 онд Сайд нарын Зөвлөлтийн дэргэд тоо бүртгэлийн төв газар байгуулж, тус улсад статистикийн нэгдсэн системийг тогтоож бэхжүүлэх талаар чухал арга хэмжээ авч бүртгэл статистикийн төвлөрсөн аппарат, орон нутагт статистикийн салбарыг буй болгосон нь хүн ам бүртгэх, мэдээлэх, мэдээ гаргах ажлын чанарыг шинэ шатанд гаргажээ. Одоо энэ ажлыг улсын хэмжээнд Улсын статистикийн газар хариуцан ажиллаж байна.

Монгол улсын хүн ам нь 1997 оны эхний байдлаар 2312.8 мянга болов. Хүн амын өсөлтийн өнгөрсөн үеийг үнлэхэд дараах дүр зураг харагдаж байна. Манжийн дарлалын үед Монгол улс хүн амынхаа хувьд мөхөж байгаа орны тоонд орж байлаа. Энэ үед эх нялхсын эндэгдэл өндөр, түүнчлэн олон сүм хийдэд эрчүүд шавилан сууж, гэр бүлгүй амьдрах явдал нилээд түгээмэл байв. Үүний нөлөөгөөр хүн амын өсөлтийн коефициент доогуур байсны зэрэгцээ удаан хугацаанд хүн амын өсөлт буурах хандлагатай байлаа. 1911 оны тусгаар тогтолц, 1921 оны Ардын хувьсгалын дараа хүн ам тогтвортой өсөх хандлага бүрдэж эхэлсэн байна. 1950-аад оны үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коефициент ерөнхийдөө буурай хөгжилтэй орнуудынхаас ойролцоо болсон байв. 1950 оны сүүлээс хүн амын өсөлтийн онцгой хурд, нялхсын нас баралтын бууралт зэргээс хүн амын өсөлтийн "тэсрэлтийн үе" эхэлсэн юм. Хүн амын тооллогын материалаас үзэхэд хүн амын дундаж өсөлт 1960–1970 онд 2.8 хувь, 1970–1980 онд 2.9 хувь байсан бол энэ үзүүлэлт буурч 1990–1995 онд 1.7 хувь болов. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөтийн жилийн дундаж хурд буурсан нь төрөлтийн бууралт, нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой гэж үзэх үндэстэй.

1960–аад онд 1000 ногдох төрөлт 43.2 байсан бол одоо 23.7 болж буурав. 1960–аад оныг өнөөгийнхтэй жишигэхэд нэг эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн тоо 7–оос 3 болон цөөрөв. Сүүлийн жилүүдэд төрсөн эхчүүдийг насын бүлгээр судлахад 30 ба түүнээс дээш насын эхчүүдийн төрөлт, ялангуяа ахимаг насын эмэгтэйчүүдийн төрөлт огцом буурч байна. Төрөлтийн буурах шалтгааныг олон хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх хөнгөлөлт багассан, эхчүүд, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр болсон, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгслийг өргөнөөр сурталчилан чөлөөтэй ашигалах нөхцөл бололцоо бүрдсэн, аборт чөлөөтэй болж, хүсээгүй төрөлтийг хязгаарлах боломжтой болсон, аж амьдралын түвшингийн доройтол зэргээр тайлбарлах боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын Их хурал хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг 1996 онд батлан гаргасан нь хүн ам зүйн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал алхам болов. Энэ бодлогод 2010–2015 он хүртлэх хугацаанд хүн амын дундаж өсөлтийг 1.8 хувиас доошгүй түвшинд хадгалж, 1990 оны түвшингээс нялхсын эндэгдлийг гуравны нэгзэр, эхийн эндэгдлийг болон 50 хувиар тус тус бууруулах зорилт дэвшиүүлсэн. Мөн эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн дээр төрөлтийг зохицстой зохицуулж, хүн амын өсөлтийг хангах тухай тодорхой заалтуудыг хамарсан. Хүн амын бодлого нь цогц шинж чанартай бөгөөд хоол хүнс, орон сууцны хангамж, боловсрол, ажил, эрхлэлт, хүн амын хөдөлгөөн, гэр бүл зэрэг харилцан уялдаа бүхий цогц асуудлын авч үзэхдээ хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настны хувьд илүү анхаарал хандууллаа. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд хүн ам зүйн судалгаа, шинжилгээний ажил, мэдээлэл, түүний үнэн бодит байдлыг онцгойлон авч үзэн иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлж, үйл ажиллагааг хангах талаар тодорхойлсон нь тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үзэж байна.

Монгол улсад хүн амын тооллого явуулж ирсэн түүхэн хөгжлийг судлан дараах дүгнэлтийг гаргаж болох байна. Үүнд:

1. Монгол улс хүн амаа 10 жилийн завсартайгаар тоолж, тооллогыг хийх талаар тодорхой дадлага хүримтлуулсан.

2. Тооллогыг явуулах боловсон хүчин тодорхой хэмжээгээр бэлтгэгдсэн.

3. Тооллогын материалыг тооцоолох техникээр боловсруулж, дүнг гаргадаг болсон.

4. Тооллогын материалыг тооцоолох техникээр боловсруулахад

4. Тооллогын материалыг тооцоолох техникээр боловсруулахад шаардагдах улсын хэмжээнд мөрдөх ангилалт, заавартай бол

5. Тооллоготой хамтруулан түүвэр судалгаа явуулдаг.

6. Тооллогыг улсын хэмжээнд тодорхой байгууллага байнга хариуцан хийлгэдэг зэрэг зохих дадлага, туршлагыг хүримтлуулсан байна.